



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2019-06-14 № 07/3294

танай _____-ны № _____-т

Журам хүргүүлэх тухай

Монгол, Хятадын хооронд улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийн олголт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг харгалзан “Монгол Улс болон БНХАУ-ын хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрлийн бичиг олгох журам”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 173 дугаар тушаалаар батлуулан хавсралтаар хүргүүлж байна.

Энэхүү журам нь зөвхөн улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг олгохтой холбогдсон танай газрын үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн болохыг анхаарч, журмын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт: 4... хуудастай.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНТУЛГА





МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийн олголт, зарцуулалтад тавих хяналт, шалгалтыг сайжруулах зорилгоор "Монгол Улс болон БНХАУ-ын хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрлийн бичиг олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтэс /Я.Мөнхжаргал/, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ /П.Дэлгэрнараран/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

1118268062 5919487 СБТ9512

МОНГОЛ УЛС БОЛОН БНХАУ-ЫН ХООРОНД БАЙНГЫН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ЗОРЧИХ ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хүрээнд улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрлийн бичиг /цаашид "зөвшөөрлийн бичиг" гэх/ олгох ажлыг хариуцан гүйцэтгэх эрх олгогдсон байгууллагын /цаашид "эрх олгогдсон байгууллага" гэх/ үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаа, хугацаа

2.1. Эрх олгогдсон байгууллага нь Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн дагуу жил бүр хятадын талтай харилцан солилцсон зөвшөөрлийн бичгийг олгох хуваарилалтыг улирлаар болон байнгын ачаа тээвэрлэлт явагдаж буй хилийн боомт бүрээр гарган Зам, тээврийн хөгжлийн яамаар /цаашид "яам" гэх/ батлуулна.

2.2. Эрх олгогдсон байгууллага нь яамны баталсан зөвшөөрлийн бичиг олгох хуваарилалтын талаарх мэдээллийг уурхай эзэмшигч буюу ачаа илгээгч болон тухайн чиглэлийн авто зам хариуцагч аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж, тээвэр зохион байгуулалтын чиглэлээр хамтран ажиллана.

2.3. Эрх олгогдсон байгууллага нь яамнаас боомт тус бүрээр баталсан зөвшөөрлийн бичгийн хуваарилалтын хүрээнд уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн боомтоор уурхай бүрээр гаргасан экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ/квот/-г үндэслэн зөвшөөрлийн бичгийг олгоно.

2.4. Эрх олгогдсон байгууллага нь уурхай эзэмшигч буюу ачаа илгээгчээс ирүүлсэн хүсэлт/тээврийн нэгдсэн системд бүртгэгдсэн мэдээлэл байна/-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасны дагуу дараах стандартын шаардлагыг хангасан аж ахуйн нэгжид зөвшөөрлийн бичгийг олгоно. Үүнд:

2.4.1. "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ." MNS 5346:2017;

2.4.2. "Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлтийн ерөнхий шаардлага." MNS 5831:2007;

МНС 6278:2011;

2.4.4. "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага." МНС 4598:2011;

2.4.5. "Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага." МНС 5345:2011;

2.4.6. "Автотээврийн салбарын ажилчдын ажил мэргэжлийн стандарт." МНС 6595:2016.

2.5. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг анх удаа авах гэж байгаа болон дараа улиралд ашиглах зөвшөөрлийн бичиг авах тээвэрлэгч аж ахуйн нэгжийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг эрх олгогдсон байгууллага батлан, цахим хуудсанд ил тод мэдээлнэ.

2.6. Эрх олгогдсон байгууллага нь дараа улиралд ашиглах зөвшөөрлийн бичиг авах хүсэлт гаргасан тээвэрлэлт гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авах, цахим мэдээллийн санд бүртгэх, баталгаажуулах ажлыг өмнөх улирлын сүүлийн сарын 15-ны дотор, зөвшөөрлийн бичиг олгох, түгээх ажлыг тухайн сарын 30-ны дотор тус тус зохион байгуулна.

2.7. Анх удаа шинээр тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн материалыг хэдийд ч авч болох бөгөөд хүсэлтийг судлан үзэж, ажлын 15 хоногийн дотор тухайн аж ахуйн нэгжид тодорхой хариу өгнө.

2.8. Эрх олгогдсон байгууллага нь тухайн улиралд олгох зөвшөөрлийн бичиг дууссан тохиолдолд энэ тухай ачаа илгээгч /уурхай эзэмшигч нарт/ аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдэгдэж, зөвшөөрлийн бичиг авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн баримт бичгийг хүлээн авахгүй.

2.9. Зөвшөөрлийн бичгийг хаяж үрэгдүүлсэн бол тухайн улиралд зөвшөөрлийн бичгийг нөхөж олгохгүй.

Гурав. Зөвшөөрлийн бичиг олгохоос татгалзах, зөвшөөрлийн бичгийг хүчингүй болгох


3.1. Эрх олгогдсон байгууллага нь дараах тохиолдолд зөвшөөрлийн бичиг олгохгүй. Үүнд:

3.1.1. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, тээврийн нэгдсэн цахим системд бүртгэхэд зөрчил гарсан;

3.1.2. Хууль тогтоомжийн хүрээнд холбогдох байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан, стандартын шаардлага хангасан эсэх талаар автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гараагүй.

3.2. Дараах тохиолдолд зөвшөөрлийн бичгийг хүчингүй болгож, хураан авч, ачаа илгээгч болон зам хариуцагч аж ахуйн нэгжид мэдэгдэнэ. Үүнд:

3.2.1. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс ноцтой осол, зөрчил гаргасан, үүний улмаас хүний амь нас эрсэдсэн бол тухайн тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичгийн хүчингүй болгоно;



3.2.2. Ачаа илгээгч болон тээвэрлэгч нарын хооронд байгуулсан тээвэрлэлтийн гэрээ цуцлагдсан;

3.2.3. Зөвшөөрлийн бичгийг гуравдагч этгээдэд дамжуулан тээвэрлэлт гүйцэтгэсэн.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Яамны дотоод хяналт шалгалт хариуцсан нэгж зөвшөөрлийн бичгийн олголт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахын зэрэгцээ, улирал тутам төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийнэ.

4.2. Эрх олгогдсон байгууллага нь зөвшөөрлийн бичгийн олголтын тайлан мэдээ, зөвшөөрлийн бичиг олгохоос татгалзсан, эсхүл хүчингүй болгосон талаарх мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллана.

4.3. Энэхүү журам болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.

-ооо-